



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/102

Хэрлэн сум

Хүн ам, орон сууцны тооллогын аймгийн,
сумын түр товчооны бүрэлдэхүүн томилж,
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн "Тооллогын тов тогтоох" тухай 76 дугаар тогтоол, Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа нийт хүн амыг хамруулан хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хүрээний мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх болон тооллогын үр дүнг тархаах зорилгоор хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын аймгийн түр товчооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, сумын хүн ам, орон сууцны тооллогын түр товчооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, тооллогын комиссын ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сум, багийн хүн ам, орон сууцны тооллогын түр товчоог 2019 оны 03 дугаар сарын 01-ний дотор байгуулан Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлыг ханган ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Аймаг, сумын комисс болон сум багийн түр товчооны ажлыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, ажлын явц байдалд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтсийн дарга /Т.Өлзийсүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2019 оны 02
дугаар сарын 26 өдрийн 1/102 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Түр товчооны дарга:	Т.Өлзийсүрэн	-Статистикийн хэлтсийн дарга, улсын байцаагч
Түр товчооны орлогч дарга:	А.Наранчимэг	-Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, улсын байцаагч
Гишүүд:	Н.Золбоо	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
	Д.Гантөгс	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
	Г.Сэдэдмаа	-Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Батхишиг	-Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Лхагвасүрэн	-Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
	А.Мөнх-уянга	-Статистикийн хэлтсийн зохион байгуулагч

Аймгийн Засаг даргын 2019 оны 02
дугаар сарын 26 өдрийн 1/02 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

СУМЫН ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Түр товчооны дарга: -Сумын Засаг даргын орлогч /Захирагчийн орлогч/
- Түр товчооны орлогч дарга: -Санхүүгийн албаны дарга
- Гишүүд:
- Нийгмийн бодлогын түшмэл
 - Газрын даамал
 - Статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- *-тухайн сумын онцлогоос хамааруулан нэмж болно.



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого зохион байгуулж явуулах төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, суманд ажиллах хүн ам, орон сууцны тооллогын комиссын / цаашид тооллогын комисс гэх / үйл ажиллагаа нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог зохицуулахад энэхүү журмыг мөрдөж ажиллана.
- 1.2. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13.5.2-т заасны дагуу байгуулагдах тооллогын комиссын зорилго нь хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэлийг харъяа нутаг дэвсгэр, эрхэлсэн асуудлын хүрээнд хангах, удирдан зохион байгуулж явуулах, урьдчилсан дүнг гаргах, тооллогын материалыг нэгтгэн Үндэсний статистикийн хороонд / УСХ /-нд хүлээлгэн өгөхөд хяналт тавьж, чиглүүлэх, тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох байгууллагуудыг ажлын уялдаа, холбоо нэгдсэн зохицуулалтаар хангахад оршино.
- 1.3. Сумын тооллогын комиссын бүрэлдэхүүнд тооллого явуулах үйл ажиллагаанд зайлшгүй оролцож ажиллах байгууллагын төлөөллийг хамруулах зарчмыг баримтална.

Хоёр. Тооллогын комиссын эрхлэх ажлын хүрээ, үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1. Тооллогын комисс Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан үүрэгтэй байна.
- 2.2. Аймгийн тооллогын комисс тухайн шатны түр товчоо, сумын тооллогын комисс тухайн шатны болон баг, хорооны түр товчоог, төрийн захиргааны төв байгууллагын тооллогын комисс харъяа байгууллагуудад түр товчоодыг байгуулж ажиллуулна.
- 2.3. Тооллогын комисс улирал, сар, 7 хоноогоор ажлаа төлөвлөж ажиллана.
- 2.4. Тооллогын комисс 2 сар тутамд ажлын явц байдлын талаарх мэдээллийг Улсын комисст хүргүүлж байна. Шаардлагатай бол тодорхой асуудлаар Улсын комиссын хуралд мэдээлэл оруулж болно.
- 2.5. Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд орон сууц, хашаа, гудамж, талбайн нэр, хаягийг цэгцлэх, анхан шатны иргэний бүртгэлийг бүрэн хөтлөх, иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулна.
- 2.6. Аймаг, нийслэлд байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, орон гэргүй хүн, албан бусаар ашигт малтмал олборлогчид болон тухайн нэгжид оршин суух бүртгэлгүй иргэдийн бүртгэлийг цэгцэлж, холбогдох мэдээллийн сангуудын мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 2.7. Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хилийг тодорхой болгох, өрхийн байршлыг тодорхойлох зорилгоор аймаг, нийслэлийн хэмжээний кадастрын мэдээллийг ашиглах боломжийг бүрдүүлнэ.

- 2.8. Хүн ам, орон сууцны тооллого болон хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын зорилго, ач холбогдол, үүнд иргэдийн оролцох үүргийн талаарх сурталчилгааг хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулна.
- 2.9. Тооллогын комисс хүн ам, өрхийн мэдээллийн сангийн ажилтнуудад зориулсан сургалтын бэлтгэлийг хангаж, чанартай зохион байгуулах бөгөөд ҮСХ-ноос явуулах сургалтад холбогдох мэргэжлийн хүмүүсийг хугацаанд нь бүрэн хамруулж, хяналт тавина.
- 2.10. Хүн ам, орон сууцны тооллого явуулах зардлын төсвийг тооцон батлагдсан нэр, төрлийн дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлагатай нэмэлт зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

Гурав. Тооллогын комиссын гишүүдийн чиг, үүрэг

- 1.1. Тооллогын комиссын даргын хариуцах ажлын чиг үүрэг
- 1.1.1. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тооллого явуулах бэлтгэлийн хангах
 - 1.1.2. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүрдэлтийг бүрэн хийх
 - 1.1.3. Тооллого явуулахтай холбогдуулан харьяа нутаг дэвсгэрийн гудамж, талбайн нэр барилга, байгууламж, орон сууцны хаягжилтыг цэгцлэх
 - 1.1.4. Тооллогод оролцож, хамтран ажиллах байгууллагуудын ажлын уялдааг зохицуулж, дэмжлэг үзүүлэх
 - 1.1.5. Улсын комисс болон Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж чиглэлийн дагуу тооллогыг зохион байгуулах
 - 1.1.6. Батлагдсан төсвийг захиран зарцуулах, зарцуулалтад хяналт тавих
 - 1.1.7. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг
- 1.2. Тооллогын комиссын орлогч даргын хариуцах ажлын чиг үүрэг
- 1.2.1. Тооллогын комиссын даргын түр эзгүйд орлох
 - 1.2.2. Статистикийн байгууллага болон тооллогын комиссын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах
 - 1.2.3. Тооллогын комисст статистик болон тооллогын асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
 - 1.2.4. Түр товчооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах
 - 1.2.5. Тооллогын ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулж явуулах
 - 1.2.6. Төсвийн тооцоог нарийвчлан гаргах
 - 1.2.7. Явцын тайлан, мэдээг нэгтгэж мэдээлэх
 - 1.2.8. Хяналтын тооллого зохион байгуулах
 - 1.2.9. Тооллогын дүнг нэгтгэж, тооллогын комисст оруулах
 - 1.2.10. Хууль тогтоомжид заасан болон ҮСХ, тооллогын комиссоос үүрэг болгосон бусад үүрэг
- 1.3. Тооллогын комиссын нарийн бичгийн даргын хариуцах ажлын чиг үүрэг
- 1.3.1. Тооллогын комиссын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж, хурлын бэлтгэлийг хангах
 - 1.3.2. Тооллогын комиссын шийдвэрийг сум, дүүргийн тооллогын комисс, бүх шатны түр товчоодод шуурхай мэдээлэх
 - 1.3.3. Тооллогын комиссын албан хэргийг хөтлөх
 - 1.3.4. Хурлын тэмдэглэл хөтөлж, гарсан шийдвэрийг албажуулах
 - 1.3.5. Тооллогын комиссын ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, явцыг мэдээлэх
 - 1.3.6. Хүн ам, орон сууцны тооллогын товчоотой байнга хамтран ажиллах

- 1.4. Комиссын бусад гишүүд нь өөрсдийн хариуцсан ажлын хүрээнд хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх бүх талын арга хэмжээг авч, явцыг комиссын хуралд тайлагнадаг байна.
- 1.5. Комиссын гишүүд нь комиссын хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, өөрийн санал дүгнэлтээ бичгээр ирүүлж, хурлаас гарах шийдвэрт тусгуулж байна.
- 1.6. Комиссын гишүүд нь энэхүү журам, комиссын шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврыг нарийн чанд мөрдөж, хэрэгжүүлнэ.

Дөрөв. Тооллогын комиссын хурлаар хэлэлцэх асуудал

- 4.1. Тооллогын комиссын гишүүдийн чиг үүргийг батлах, өөрчлөлт оруулах, сум, дүүргийн тооллогын комиссын мэдээллийг авч хэлэлцэн, тулгамдаж байгаа асуудлаар шийдвэр гаргах
- 4.2. Тооллогын комиссын ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн явцыг хэлэлцэх, холбогдох зохицуулалтыг хийх, шат шатанд завсрын тооллогын бэлтгэлийг хянах ажлыг зохион байгуулах, үнэлэлт, дүгнэлт өгөх
- 4.3. Тооллоготой холбоотой бусад асуудал

Тав. Хурлын дэг

- 5.1. Тооллогын комиссын хурлыг дарга, түүний эзгүйд орлогч дарга удирдан явуулна.
- 5.2. Тооллогын комиссын хурлыг гишүүдийн 75-аас доошгүй хувийн ирцтэй үед хуралдуулах бөгөөд улирал тутам зохион байгуулна.
- 5.3. Асуудлыг хуралд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ. Хурлыг хуваарийн дагуу хийнэ.

Зургаа. Хурлын шийдвэр

- 6.1. Хурлаар хэлэлцсэн асуудлаар гарсан санал, дүгнэлт шийдвэрийг тэмдэглэл үйлдэж, шаардлагатай асуудлаар тооллогын комиссын даргын захирамж гаргаж баталгаажуулна.